БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Булган сумын тохижилт үйлчилгээний ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/139/НА-СТА-ТШЗ


Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг

2022 он

Дарга,
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: З.Ганбаатар
Утас: 70342495 Цахим хаяг: ganbaatarz@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт ........................................................ **Error! Bookmark not defined.**

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................................ 5

3. Аудитын тайлан ........................................................ 9

3.1 Ерөнхий зүйл ........................................................ 9

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........................................................ 9

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................................ 9

3.4 Материаллаг байдал ........................................................ 10

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........................................................ 10

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........................................................ 10

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........................................................ 11

3.8 Аудитын гол асуудал ........................................................ 11

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........................................................ 11

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................................ 12

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................................ 12

4. Аудитын илрүүлэлт ........................................................ 12

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........................................................ 14

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 130

танай________________ны №________________т

ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АНГИЙН ДАРГА А.ГАНБОЛД
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тохижилт үйлчилгээний ангийн 2021оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Тохижилт үйлчилгээний ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлүүд нь санхүүгийн тайланд материаллаг бөгөөд өргөн тархаагүй байна. Үүнд:

- Тайлант онд нийт 8,661,859.92 /найман сая зургаан зуун жаран нэгэн мянга найман зуун тавин есөн төгрөг ерэн хоёр/ төгрөгийн өглөг, авлагатай тайлагнасан;
- Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3 төрлийн 29,250,000.00 /хорин есөн сая хоёр зуун тавин мянга/ төгрөгийн хөрөнгийг дахин үнэлээгүй зөрчлүүд нь УСНББОУС-17, Засгийн газрын 2006 оны 388 дугаар тушаалын нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.41-т "Биет хөрөнгийн дансны үнэ бодит үнээс материаллаг хэмжээний зөрүүтэй байх нөхцөлд хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3, 20.2.4, 20.2.5, 20.2.6 санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой, оршин байх, үнэн зөв, ангилал, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

D:/bichighereg/2022A4toot

006020063

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 70,108,016.64 | 90,892,156.00 |
| 33 | АВЛАГА | 79,726.64 | 2,640,672.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 79,726.64 | 2,449,203.00 |
| 335 | Бусад авлага | - | 191,469.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | - | 191,469.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 70,028,290.00 | 88,251,484.00 |
| 351 | Түүхий эд материал | 3,919,000.00 | 72,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,919,000.00 | 72,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 66,109,290.00 | 88,179,484.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 250,000.00 | 206,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 21,963,650.00 | 23,041,250.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 18,433,560.00 | 11,307,400.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,029,180.00 | 654,070.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 18,378,100.00 | 41,876,560.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,826,850.00 | 10,583,104.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 2,227,950.00 | 511,100.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 8,433,970,371.49 | 8,697,114,080.52 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 8,433,970,371.49 | 8,697,114,080.52 |
| 392 | Биет хөрөнгө | 7,477,330,371.49 | 7,740,474,080.52 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 984,728,057.85 | 1,195,561,469.18 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (125,818,933.75) | (153,075,991.56) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 650,706,102.00 | 650,706,102.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (257,831,615.40) | (295,734,654.14) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,037,094,397.55 | 1,090,383,611.55 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (184,332,139.01) | (236,161,347.59) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 303,389,700.00 | 303,389,700.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (293,448,349.22) | (294,237,834.14) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 2,799,991,700.15 | 2,799,991,700.15 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (729,753,617.61) | (822,758,329.41) |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 388,889.00 | 388,889.00 |
| 39212 | Хуримтлагдсан элэгдэл | (249,536.98) | (268,981.42) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 591,564,945.90 | 771,354,945.90 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,202,125,534.28 | 3,343,015,534.28 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (501,224,763.27) | (612,080,733.28) |
| 393 | Биет бус хөрөнгө | 956,640,000.00 | 956,640,000.00 |
| 39301 | Програм хангамж | 650,000.00 | 650,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (150,000.00) | (150,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 956,140,000.00 | 956,140,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 8,504,078,388.13 | 8,788,006,236.52 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 1,235,062.92 | 6,021,187.92 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,235,062.92 | 6,021,187.92 |
| 413 | Өглөг | 1,235,062.92 | 6,021,187.92 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 346,962.92 | 278,274.92 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 5,144,813.00 |
| 4136 | Бусад өглөг | 888,100.00 | 598,100.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 888,100.00 | 598,100.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 8,502,843,325.21 | 8,781,985,048.60 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 8,502,843,325.21 | 8,781,985,048.60 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 5,103,290,133.50 | 5,103,290,133.50 |
| 51101 | Өмч: - төрийн | 5,103,290,133.50 | 5,103,290,133.50 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 2,979,329,565.94 | 3,293,506,590.13 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,979,329,565.94 | 3,014,364,866.74 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 279,141,723.39 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 420,223,625.77 | 385,188,324.97 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 8,504,078,388.13 | 8,788,006,236.52 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **648,240,838.55** | **1,426,543,283.59** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **112,256,938.55** | **632,895,883.59** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 112,256,938.55 | 632,895,883.59 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 112,256,938.55 | 632,895,883.59 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 90,000.00 | 2,250,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 112,166,938.55 | 630,645,883.59 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **535,983,900.00** | **793,647,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 390,954,200.00 | 630,239,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 390,954,200.00 | 630,239,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 50,575,000.00 | 68,953,300.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 47,000,000.00 | 68,953,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,575,000.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 94,454,700.00 | 94,454,700.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 94,454,700.00 | 94,454,700.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **695,514,472.91** | **1,114,908,026.64** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **695,514,472.91** | **1,114,908,026.64** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 695,333,028.91 | 1,114,738,329.64 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 544,070,950.36 | 789,709,042.64 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 544,070,950.36 | 789,709,042.64 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 151,262,078.55 | 325,029,287.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 151,262,078.55 | 325,029,287.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 181,444.00 | 169,697.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 181,444.00 | 169,697.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 181,444.00 | 169,697.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(47,273,634.36)** | **311,635,256.95** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,518,000.00 | 32,493,533.56 |

| | | | |
|---|---|---|---|
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,518,000.00 | 32,493,533.56 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (1,518,000.00) | (32,493,533.56) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(48,791,634.36)** | **279,141,723.39** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 5,103,290,133.50 | 420,223,625.77 | 3,027,935,582.22 | 8,551,449,341.49 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 185,618.00 | 185,618.00<br>- |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 5,103,290,133.50 | 420,223,625.77 | 3,027,935,582.22 | 8,551,634,959.49 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | | |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | -48,791,634.36 | -48,791,634.36 |
| C08 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 5,103,290,133.50 | 420,223,625.77 | 2,979,329,565.86 | 8,502,843,325.13 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 5,103,290,133.50 | 420,223,625.77 | 2,979,329,565.86 | 8,502,843,325.13 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 35,035,300.80 | 35,035,300.80 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 5,103,290,133.50 | 420,223,625.77 | 3,014,364,866.66 | 8,537,878,625.93 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -35,035,300.80 | 00.00 | -35,035,300.80 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 279,141,723.39 | 279,141,723.39 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 5,103,290,133.50 | 385,188,324.97 | 3,293,506,590.05 | 8,781,985,048.52 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 536,073,900.00 | 795,897,400.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 90,000.00 | 2,250,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 90,000.00 | 2,250,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 90,000.00 | 2,250,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 90,000.00 | 2,250,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 535,983,900.00 | 793,647,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 390,954,200.00 | 630,239,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 390,954,200.00 | 630,239,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 50,575,000.00 | 68,953,300.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 47,000,000.00 | 68,953,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,575,000.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 94,454,700.00 | 94,454,700.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 94,454,700.00 | 94,454,700.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 536,073,900.00 | 795,897,400.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 536,073,900.00 | 795,897,400.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 535,892,456.00 | 795,727,703.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 530,447,456.00 | 774,693,453.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 530,447,456.00 | 774,693,453.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,445,000.00 | 21,034,250.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,445,000.00 | 21,034,250.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 181,444.00 | 169,697.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 181,444.00 | 169,697.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 181,444.00 | 169,697.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 134097600.00 | 724693478.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 134097600.00 | 724693478.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 134097600.00 | 724693478.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 134,097,600.00 | 724,693,478.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 134,097,600.00 | 724,693,478.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 630,239,400.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | - | 630,239,400.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | - | 630,239,400.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **71,034,225.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **71,034,225.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 71,034,225.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 50,149,975.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 50,149,975.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 20,884,250.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 20,884,250.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 68,953,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 68,953,300.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 68,953,300.00 |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | 0 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | 0 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 0 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 0 |

**3. Аудитын тайлан**

## 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын тохижилт үйлчилгээний ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Аудитор З.Ганбатаар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын тохижилт үйлчилгээний ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Булган сумын тохижилт үйлчилгээний анги нь “нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, ногоон байгууламж, автозам засвар үйлчилгээг стандартын дагуу үзүүлэх, дээрх нийтийн үйлчилгээний чиглэлээр болоод гэрэлтүүлэг, хог хаягдлын менежментийг сайжруулах, хамгаалах, төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагааг эрхлэх, нэгдсэн удирдлагаар хангах, өөрийн үйлдвэрийн автомашин механизм, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах, сумын нийтийн үйлчилгээг хөгжүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 онд Булган сумын засаг даргын удирдамжийн дагуу зөвлөн туслах үйл ажиллагааны комисс гарч байгууллага дээр ажиллаж заавар зөвлөгөө өгсөн.

Тохижилт үйлчилгээний ангийн бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс нь 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тохижилт үйлчилгээний ангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 697.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 6.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тохижилт үйлчилгээний ангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 283,927.0 мянган төгрөгөөр буюу 3.3 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

*/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 79,726.64 | 2,640,672.00 | 2,560,945.36 |
| Урьдчилгаа | 0 | 0 | |
| Бараа материал | 70,028,290 | 88,251,484 | 18,223,194.00 |
| Үндсэн хөрөнгө | 8,433,970,371.49 | 8,697,114,080.52 | 263,143,709.00 |
| Нийт хөрөнгө | 8,504,078,388.13 | 8,788,006,236.52 | 283,927,848.4 |
| Өр төлбөр | 1,235,062.92 | 6,021,187.92 | 4,786,125.00 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 8,502,843,325.21 | 8,781,985,048.60 | 279,141,723.39 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 8,504,078,388.13 | 8,788,006,236.52 | 283,927,848.39 |

**Авлага:** дансны үлдэгдэл 2,640.0 мянган төгрөг болж 2,560.9 мянган төгрөгөөр өссөн ХХОАТ үүссэнээс шалтгаалжээ.

**Бараа материал:** Бараа материалын оны эхний үлдэгдэл 70,028.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 88,251.5 сая төгрөг болж өмнөх оноос 18,223.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд 222,900.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр  сая төгрөгийн бараа материал худалдан авч, дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 5.1 сая төгрөгийн материал  тус тус нэмэгдэж орлогоор тусгасан байна.

**Үндсэн хөрөнгө:** Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,788,006.24 мянган төгрөг болж 263143.71 мянган төгрөгөөр өссөн нь Саятан хаалганы тохижилт, Андагчдын хаалганы бие засах газар, шинээр нүүж байгаа байрны контор, дулааны шугам, гарш зэрэг үндсэн хөрөнгө нэмж хүлээн авсан нь  шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 0 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 620,666.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

**Өр төлбөр:** дансны үлдэгдэл 6,021.19 мянган төгрөг болж 4,786.13 мянган төгрөгөөр өссөн нь Булган мээж ТӨК-ны халаалт дулааны төлбөр болон бусад хувь хүмүүст өгөх төлбөрийн боломжгүй байсан нь шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 724.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 724.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн урсгал үйл ажиллагааны арга хэмжээг хэрэгжүүлэхээр 724.7 сая төгрөгийн төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 630.2 сая төгрөгийн, ОНХСангаас 94,45 сая төгрөг нийт 724,69 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 724,69 сая төгрөгийг зарцуулж 0. сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймаг, сумын засаг даргын нөөц хөрөнгөөс 68.9 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2.3 сая нийт 71.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс нийт зардалд 71.0 сая төгрөгийг зарцуулж 0.2 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тайлант онд Батлагдсан төсвөөс төсвийн хэмнэлт гараагүй.

### 3.8 Аудитын гол асуудал

- ✓ Тайлант онд нийт 8,661,859.92 төгрөгийн өглөг, авлагатай тайлагнасан,
- ✓ Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3 төрлийн 29,250,000.0 төгрөгийн хөрөнгийг дахин үнэлээгүй зэрэг асуудал байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тулган баталгаажуулахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.3, 6.1.5, 6.2.4, 6.4.1, дахь заалтад заасан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь тухайн хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

Таван сая төгрөгөөс дээш 42 удаагийн 1,006,106,794.0 төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.4 дэх заалтыг зөрчсөн байна. Энэ нь Шилэн дансны тухайн хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдлийг бүрдүүлж хавсаргаагүй, төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн иж бүрдэл бүрэлдэхүүн хэсгийн дагуу тайлангаа ирүүлээгүй.

Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 төгрөгийн дансны үнэтэй 29,250,000.0 төгрөгийн 3 хөрөнгийн тайлагнасан байна. Энэ нь УСНББОУС-17, Засгийн газрын 2006 оны 388 дугаар тушаалын нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.41-т "Биет хөрөнгийн дансны үнэ бодит үнээс материаллаг хэмжээний зөрүүтэй байх нөхцөлд хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шилэн дансны цахим хуудсанд төсөв, өмч хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэр, таван сая төгрөгөөс дээш орлогын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтад заасан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь тухайн хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар нийт 634.0 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс 208.0 мянган төгрөгийн төлбөрийн акт алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар байгууллагад тэг өртөгтэй хөрөнгийг хуульд зааснаар үнийг шинэчлэн тогтоож ажилласан байгааг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

**4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 1,462,519.2 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 416,687.2 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 1,813.4 сая төгрөгийн 1 төлбөрийн актыг тогтоож, 1,044,018.7 мянган төгрөгийн зөрчилд таслан зогсоох 4 албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч ажиллаа.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд 416,687.2 мянган төгрөгийн үнэ төлбөргүй авсан хөрөнгийн бүртгэлд тусгаагүй нь НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." 15.2 дахь "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна." гэсэн заалтын дагуу залруулга хийсэн.

4.2 Төлбөрийн акт

Тайлант онд гэрээний дагуу 60,445,050.0 төгрөгийн шатахууны худалдан авалт хийсний 3 хувийн шатахууны буцаан авалт болох 1,813,351.0 төгрөгийн шатахууныг нярвын тайланд тусгаагүй анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

Тайлан онд 2,640,672.0 төгрөгийн авлага, 6,021,187.92 төгрөгийн өглөгтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 төгрөгийн дансны үнэтэй 29,250,000.0 төгрөгийн 3 хөрөнгийн тайлагнасан байна. Энэ нь УСНББОУС-17, Засгийн газрын 2006 оны 388 дугаар тушаалын нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.41-т "Биет хөрөнгийн дансны үнэ бодит үнээс материаллаг хэмжээний зөрүүтэй байх нөхцөлд хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

4.4 Албан шаардлага

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тулган баталгаажуулахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.3, 6.1.5, 6.2.4, 6.4.1, дахь заалтад заасан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь тухайн хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй..

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

4.5 Албан шаардлага

Таван сая төгрөгөөс дээш 42 удаагийн 1,006,106,794.0 төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.4 дэх заалтыг зөрчсөн байна. Энэ нь Шилэн дансны тухайн

хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

4.6 Албан шаардлага

Тайлан онд 2,640,672.0 төгрөгийн авлага, 6,021,187.92 төгрөгийн өглөгтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

4.7 Албан шаардлага

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдлийг бүрдүүлж хавсаргаагүй, төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн иж бүрдэл бүрэлдэхүүн хэсгийн дагуу тайлангаа ирүүлээгүй.

Шийдвэрлэсэн байдал: Зөвлөмж.

**Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:**

***1. Зардлын данстай холбоотой асуудал***

1.1. *Илрүүлэлт:*

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тодруулга тайлан нь холбог хууль тогтоомжийн дагуу иж бүрэн ирүүлээгүй болно.

Энэ нь төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

*/сая.төгрөгөөр/*

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Булган сумын ТҮА | 7 | 1,462.5 | 1 | 416.7 | 1 | 1.8 | 4 | 1,044.0 | 1 | 0 |
| Нийт дүн | | 7 | 1,462.5 | 1 | 416.7 | 1 | 1.8 | 4 | 1,044.0 | 1 | 0 |